



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/616

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтайн оргил констракшн” ХХК-ий хийж гүйцэтгэсэн Ойн зурваст хайс хийх /Зэрэг сум, Хөндлөн баг/-н ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Дөлбадрал -Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга

Гишүүд:

Х.Баасанхүү -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

М.Баярт - Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Б.Бурмаа -Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж -Аймгийн архивын тасгийн дарга

Х.Уранболд -“Алтайн оргил констракшн”ХХК-ий захирал

Нарийн бичгийн  
дарга:  
Д.Тогтохбаяр

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын Барилга хот байгуулалтын  
хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. "Алтайн оргил констракшн" ХХК-ий хийж гүйцэтгэсэн ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн дотор багтаан захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН